



АТАР-ӨРГӨӨ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 27 өдөр

№ 14

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компаний тухай хуулийн 61.1.2, 61.2, 61.3, 61.4 дүгээр зүйл,
Компаний дүрмийн дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 –р
тогтоол, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны 12 сарын 27-ны өдрийн хурлын шийдвэрийг
үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Атар-Өргөө ХК-ний Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2023 оны 02 сарын 06-ны өдрийн 09:00 цаг компаний байр /Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Чингисийн өргөн чөлөө-20_, Атар-Өргөө ХК-ны байрны хурлын танхим/-д хуралдуулсугай.
2. Хурлаар эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дор дурдсан асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтоосугай. Үүнд:
 - a. Хувьцаат компанийг хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон хэлбэрийг өөрчлөх
 - b. Компанийг өөрчлөх төслийг танилцуулж, дүрмийг шинэчилж батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг дор дурьдсан бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсугай.
 - i. Комиссын дарга Б. Мөнхдалай /ГУЗ-ийн дарга/
 - ii. Гишүүн С. Баярмаа /ГУЗ-ийн нарийн бичгийн дарга/
4. Хурал бэлтгэх зохион байгуулах комисст даалгах нь:
 - a. Компаний ээлжит бус хурлыг хуралдуулах тухай Хурлын мэдэгдлийг холбогдох бичиг баримтын хамт 2022 оны 12 сарын 30-ны дотор Санхүүгийн зохицуулах хороо болон арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлэх,
 - b. Компаний хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах тухай зар мэдээг 2023 оны 01 сарын 02-ны өдрийн дотор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр /өдөр тутмын сонин телевиз/ болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх,
 - c. Энэхүү мэдээллийг 15 хоногийн дараа анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэх,
 - d. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, тэдгээрийн танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төсөл, санал авах хуудсыг үнэт цаасны брокер, дилерийн компанид хэвлэмэл болон цахим хэлбэрээр 2023 оны 01 сарын 06-ны дотор хүргүүлэх,

- е. Хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл болон хувьцаа эзэмшигчдэд танилцуулах бичиг баримтыг 2022 оны 12 сарын 26-ны өдрөөс 2023 оны 01 сарын 25-ны өдрийн дотор хувьцаа эзэмшигчдэд танилцуулж, саналын хуудсаар санал авах
5. Ээлжит бус хурлын “Санал авах хуудас”-ны загварыг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
 6. Ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 1 дүгээр сарын 20-ны өдрөөр тогтоосугай.
 7. Хуралд биеэр оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудсыг хүллэж авах сүүлийн хугацааг 2022 оны 01 сарын 26-ны 17.00 цагаар тогтоосугай.
 8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б. Мөнхдалайг сонгосугай.
 9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын даргаар Ц.Мөнхтуул, гишүүдээр М.Солонго, Т.Сэрээтэр нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

ГИШҮҮД




Б.МӨНХДАЛАЙ


Б.ГАНБАТ


Ж.САЙНБИЛЭГ


Г.ЭНХБОЛД


М.МӨНХТЭНГИС


Т.БАТТУЛГА


Т.ЖИГМЭДДАГВА


С.БЯМБАХОРЛОО


Т.БОЛОРМАА